



**НИЙСЛЭЛИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
АЛБАН ДААЛГАВАР**

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

┌ Төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн  
байгууллагууд эрүүл аюулгүй орчинг  
бүрдүүлж ажиллах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 03, “Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын удирдлагуудад ДААЛГАХ нь:

**1. Эрүүл ахуйн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр:**

1.1 Төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.4.3. “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх” гэсэн заалтыг хэрэгжүүлж, тохижилт, аюулгүй байдлыг хангах;

1.2 Мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6. “Нийтийн эзэмшлийн зам, талбайг хог хаягдал, тогтоол ус, цас, мөсгүй байлгах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, шат, хашлага, хайсыг бүрэн бүтэн байлгах”, гэр хорооллын нүхэн жорлонгийн бохироос үүдэх хөрсний бохирдлыг бууруулахад иргэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдэнд чиглэсэн сургалт сурталчилгааг тогтмол хүргэх;

1.3 Нийтийн эзэмшлийн болон үйлчилгээний газар, орон сууцны орчныг нус, шүлс, цэр, тамхины иш, гэрийн тэжээвэр амьтны ялгадсаар бохирдуулах, зориулалтын бус газарт бие засах, хог хаягдлыг ил задгай хаях, шатаахгүй байх, хор уршийг иргэдэд таниулах, ухуулга нөлөөллийн ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран явуулах.

**2. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Хот нийтийн аж ахуйн чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 03 дугаар албан даалгаврын биелүүлэх чиглэлээр:**

2.1 Төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр байгууллагынхаа гадна талбайд хог хаягдлыг ангилан ялгах хогийн савыг 10-15 метр тутамд байрлуулах;

2.2 Төв зам дагуу байрладаг төр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага бүр орчны тохижилтыг сайжруулж, эрчим хүч, шугам сүлжээ, инженерийн байгууламжийн аюулгүй байдал, шаардлагатай тоног төхөөрөмжөөр ажилтан, албан хаагчдыг хангах;

2.3 Хаяг, мэдээллийн байгууламжийг холбогдох журмыг дагуу байршуулах, шинэчлэн засварлах, шинээр хийлгэх.

### **3. Нийслэлийн Засаг даргын 2019 оны “Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх чиглэлээр:**

3.1 Иргэдийн эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах;

3.2 Хүүхдийн насны онцлогт тохирсон эрүүл, зөв хооллолт, өвчин эмгэг болон осол гэмтэл, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх талаар зөвлөмж гаргаж эцэг, эх, асран хамгаалагч нарт ухуулан таниулах;

3.3 Өсвөр үе, залууст гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвараас сэргийлэх, архи, тамхи, согтууруулах ундаа, хар тамхи, мансууруулах бодист донтох эрсдлээс сэргийлэх сургалт, сурталчилгааг явуулах;

3.4 Иргэдэд хайхрамжгүй, хариуцлагагүй байдлаас үүдэх осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа бага насны хүүхдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эцэг эх асран хамгаалагч нарын үүрэг, хариуцлагыг өндөржүүлж, эрсдэлгүй эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, зөв дадал хандлагыг хэвшүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах,

3.5 Гал түймрээс урьдчилан сэргийлэх, угаартах, хордох, хөлдөх гэх мэт гэнэтийн аюул осолд өртөхөөс сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх.

3.6 Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартыг мөрдөх, эрүүл аюулгүй орчинд ажиллах нөхцлийг хангах, ажилтан албан хаагчдад эрүүл зан үйл төлөвшүүлэх, зөв дадлыг бий болгох чиглэлээр сургалт явуулж “Бидний эрүүл мэнд-Аюулгүй байдал” сэдвийн дор тодорхой ажлыг зохион байгуулах;

### **4. Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгах нь:**

4.1 Энэхүү албан даалгаврыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.2 Албан даалгаврын хэрэгжилтийн тайланг сар бүрийн 15 болон 30-ны өдөр Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст албан бичгээр болон /ts.undral2010.03.20@gmail.com/ цахим хэлбэрээр ирүүлэх.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР